Өвөр монголын иргэдийн эрүүл мэндийн цагаан толгойн (health literacy) талаарх мэдлэгийг үнэлэх нь

Хун Ян[1], Д.Солонго[2], Ц.Лхагвасүрэн[2], С.Наранчимэг[2]

[1]Өвөр Монголын Үндэстний Их Сургууль
[2]АШУҮИС
Email: 03hongyan@163.com, Утас: 99562948

Түлхүүр үг:

Өвөр Монгол
Эрүүл мэнд
Эрүүл мэндийн мэдлэг, үнэлгээ

Товч утга: Сүүлийн жилүүдэд олон улс оронд "Эрүүл мэндийн цагаан толгойн" (Health Literacy) мэдлэгийг үнэлсэн судалгааны ажлууд хийгдэж, улмаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт өөрчлөлт гарч буй үр дүнг өргөн цар хүрээтэй авч үзэх болжээ. Зорилго: Өвөр Монголын иргэдийн Эрүүл мэндийн цагаан толгойн мэдлэгийг үнэлэхэд оршино. Арга аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар хийв. Судалгаанд ӨМӨЗО-ны нийт 742 иргэнийг хамруулж, ДЭМБ-аас гаргасан "Health Literacy" асуулгыг хэрэглэв. Түүврийг АНУ-ын судлаач Price, Dake, Murnan нарын боловсруулсан таблицийн аргыг хэрэглэв. Статистикболовсруулалтыг судалгааны SPSS-23-ыг ашигл хийв. Үр дүн: Судалгаанд хамрагдасдын 9% нь 18-30 насныхан, 38.5%-ийг 31-40 насныхан, 22.1%-ийг 41-50 насныхан, 8.2%-ийг 61 ба түүнээс дээш насныхан байна. Иргэд өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг 54.2 % нь сайн, 1.2% нь маш муу гэж үнэлжээ. Иргэдийн эрүүл мэндийн байдлыг үнэлэхэд нэг ба түүнээс олон удааөвдсөн нь 37.8%, 33.4% нь тамхи татдаг, 67.8% нь архины хэрэглээтэй байна. Иргэд өөрийн эрүүл мэндээ сайжруулах талаар шийдвэр гаргахдаа 3.4% нь маш хүндрэлтэй, 49.3% нь хүндрэлтэй байдаг. Судалгаанд хамрагдагсдын дасгал хөдөлгөөнд хамрагддаг байдлыг судлахад 58.8% нь хялбархан, харин 1.3% нь маш хүндрэлтэй гэж хариулжээ. Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан нутгийн иргэд өөрсдийнхөө эрүүл мэндийг тааруухан ба түүнээс доогуур (37.5%) үнэлсэн, олон удаа өвдөж, эмнэлэгт ханддаг (37.8%), тэдний 33.4% нь тамхи татдаг, эрүүл мэндээ сайжруулахад мэдлэг чадвар дутмагаас шийдвэр гаргахад хүндрэлтэй (49.3%) байгаа нь хүн амын тодорхой бүлэг дунд эрүүл мэндийн талаар мэдлэг, чадвар олгох сургалтын хэрэгцээ байгааг харуулж байна.

Үндэслэл: АНУ-ын судлаач Scott Simonds 1974 онд олон улсын эрүүл мэндийн боловсролын их хурал дээр эрүүл амьдрах ухаанд сургах нь төрийн бодлогын асуудал болгон дэвшүүлж, Health Literacy (эрүүл мэндийн цагаан толгой) гэх ухагдахуун буюу нэр томьёог анх удаа хөндсөн байна.Сүүлийн жилүүдэд олон улс оронд "Эрүүл мэндийн талаарх мэдлэг буюу эрүүл мэндийн цагаан толгойн" мэдлэгийг үнэлсэн судалгааны ажлууд хийгдэж, улмаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт өөрчлөлт гарч буй үр дүнг өргөн цар хүрээтэй авч үзэх болжээ. Бүгд Найрамдах Хятад Ард Улс иргэдийнхээ эрүүл мэндийн талаарх мэдлэгийг (Health Literacy) үнэлэх талаар 2008 онд гаргасан баримт бичигтээ анх удаа нийтэлсэн байна. "Эрүүл Хятад 2030" гэсэн стратеги төлөвлөгөөг БНХАУ 2016 онд боловсруулж, ард иргэдийн эрүүл мэндэд эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлд суурилан, тэднийг эрүүл аж төрөхөд туслах, дэмжих, үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулж, эрүүл орчныг бүрдүүлэн улмаар хүн амын эрүүл мэндийн түвшнийг дээшлүүлнэ гэж тусгажээ.

Зорилго: Өвөр Монголын Өөртөө засах орны иргэдийн Эрүүл мэндийн цагаан толгойн (Health literacy) талаарх мэдлэгийг үнэлэхэд оршино.

Арга аргачлал: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар хийв. Судалгаанд БНХАУ-ын ӨМӨЗО-ны зүүн бүсээс Тун Ляо хот, Шийн Мийн тойрог, Талын айл сум, дунд бүсээс Хөх хот, Чинг Цэнг тойрог, Баян сум, баруун бүсээс Бугат хот, Дүн Хээ тойрог, Хээ Дүн сумын нийт 742 хамруулж, ДЭМБ-аас гаргасан "Иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг үнэлэх" (Health Literacy) асуулгын хуудсыг хэрэглэн, 2018 оны 10-р сараас 2019 оны 5-р сарын хооронд авав. Түүврийг АНУ-ын Ohio мужийн Toledo-ийн Их Сургуулийн эрдэмтэн судлаач Price, Dake, Murnan, Dimmig, Akpanudo нарын 2005 онд боловсруулсан таблицийн аргыг хэрэглэв. Боловсруулалтыг статистик судалгааны SPSS-23-ыг ашиглаж боловсруулав.

Үр дүн: Судалгаанд хамрагдасдын 9%-ийг (67) 18-30 насныхан, 38.5%-ийг (286) 31-40 насныхан, 22.1%-ийг

(164) 41-50 насныхан, 8.2%-ийг (61) 61 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Судалгаанд хамрагдагсдын 48.4% нь эрэгтэй, 51.6% нь эмэгтэйчүүд байв. Иргэд өөрийнхөө эрүүл мэндийн байдлыг үнэлэхдээ 54.2 % нь сайн 1.2% нь маш муу гэж хариулжээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Иргэд өөрийнхөө эрүүл мэндийн байдалд хийсэн үнэлгээ


№	Үнэлгээ	Тоо	Хувь	Хариулсан тоонд бодсон хувь	Давтамжийн нийлбэр хувь
1	Маш сайн	62	8.4	8.4	8.4
2	Сайн	402	54.2	54.2	62.5
3	Тааруухан	207	27.9	27.9	90.4
4	Муу	62	8.4	8.4	98.8
5	Маш муу	9	1.2	1.2	100.0
	Нийт	**742**	100.0	100.0	

Иргэдийн эрүүл мэндийн хувьд асуудалтай байсан эсэхэд дүн шинжилгээ хийхэд: Нэг ба түүнээс олон удааөвдсөн гэж 37.8% нь, харин 8.4% нь мэдэхгүй гэж хариулсан нь тухайн бүлгийн хүн амд өөрийн эрүүл мэндийн талаар тодорхой мэдлэг олгох шаардлага байгааг харуулж байна(Хүснэгт 2).

Хүснэгт 2. Иргэдийн хувьд эрүүл мэндийн асуудалтай байдал

№	Үнэлгээ	Тоо	Хувь	Хариулсан тоонд бодсон хувь	Давтамжийн нийлбэр хувь
1	Нэгээс олон удаа	113	15.2	15.2	15.2
2	Нэг удаа	168	22.6	22.6	37.9
3	Үгүй	399	53.8	53.8	91.6
4	Мэдэхгүй	62	8.4	8.4	100.0
	Нийт	**742**	**100.0**	**100.0**	

Судалгаанд хамрагдагсдын хорт зуршлын хэрэглээг судлахад 33.4% нь тамхи татдаг, 11.3% нь тамхи татдаг байснаа больсон, 55.3% нь тамхи огт татдаггүй байна (Зураг 1).



Зураг 1. Иргэдийн тамхины хэрэглээ

Судалгаанд хамрагдагсдын 19% нь 7 хоногт олон удаа, 20.8% нь долоо хоногт 1 удаа, 23.2% нь сард 1 удаа, харин 32.2% нь архийг огт хэрэглэдэггүй байна (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Иргэдийн архины хэрэглээ

№	Тоо	Хувь	Хариулт өгсөн хүний тоонд бодсон хувь	Давтамжийн нийлбэр хувь
Долоо хоногт нэлээд удаа	141	19.0	19.0	19.0
Долоо хоногт нэг удаа	154	20.8	20.8	39.8
Сард нэг удаа	172	23.2	23.2	62.9
Хэзээ ч үгүй	239	32.2	32.2	95.1
Мэдэхгүй	36	4.9	4.9	100.0
Нийт	742	100.0	100.0	

Иргэд өөрийн эрүүл мэндээ сайжруулах талаар шийдвэр гаргадаг байдалд дүн шинжилгээ хийхэд: 3.4% нь маш хүндрэлтэй, харин 49.3% нь хүндрэлтэй байдаг гэж хариулсан нь эрүүл мэндээ сайжруулах шийдвэр гаргах мэдлэг чадвар дутаж байгаагийн илрэл учир хүн амын тодорхой бүлэг дунд эрүүл мэндийн талаар мэдлэг, чадвар олгох сургалтын хэрэгцээ байна (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Эрүүл мэндээ сайжруулах талаар шийдвэр гаргадаг байдал

№	Үнэлгээ	Тоо	Хувь	Хариулт өгсөн хүний тоонд бодсон хувь	Давтамжийн нийлбэр хувь
1	Маш хялбархан	31	4.2	4.2	4.2
2	Хялбархан	272	36.7	36.7	40.8
3	Мэдэхгүй	48	6.5	6.5	47.3
4	Хүндрэлтэй	366	49.3	49.3	96.6
5	Маш хүндрэлтэй	25	3.4	3.4	100.0
	Нийт	742	100.0	100.0	

Судалгаанд хамрагдагсад өөрийн хүссэн спортын клуб, дасгал хөдөлгөөний ангид хамрагддаг талаарх байдлыг судлахад 58.8% нь хялбархан гэсэн хариултыг сонгосон бол хамгийн цөөн буюу нийт хариултын 1.3% нь маш хүндрэлтэй гэсэн хариултыг сонгосон байна(Хүснэгт 5).

Хүснэгт 5. Дасгал хөдөлгөөн хийдэг байдал

№	Үнэлгээ	Тоо	Хувь	Хариулт өгсөн хүний тоонд бодсон хувь	Давтамжийн нийлбэр хувь
1	маш хялбархан	106	14.3	14.3	14.3
2	хялбархан	436	58.8	58.8	73.0
3	мэдэхгүй	50	6.7	6.7	79.8
4	хүндрэлтэй	140	18.9	18.9	98.7
5	маш хүндрэлтэй	10	1.3	1.3	100.0
	Нийт	742	100.0	100.0	

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан нутгийн иргэд өөрсдийнхөө эрүүл мэндийг тааруухан ба түүнээс доогуур (37.5%) үнэлсэн, олон удаа өвдөж, эмнэлэгт ханддаг (37.8%), тэдний 33.4% нь тамхи татдаг, эрүүл мэндээ сайжруулахад мэдлэг чадвар дутмагаас шийдвэр гаргахад хүндрэлтэй (49.3%) байгаа нь хүн амын тодорхой бүлэг дунд эрүүл мэндийн талаар мэдлэг, чадвар олгох сургалтын хэрэгцээ байгааг харуулж байна.

Ном зүй:

1. *Glenda Denson Knight. An Evaluation of the Health Literacy Knowledge and Experience of Registered Nurses in Georgia. A dissertation submitted to the Graduate Faculty of Auburn University, for the Degree of Doctor of Philosophy. Auburn, Alabama. 2011*
2. *Ruth M. Parker. Understanding Health Literacy. American Medical Association. 2003.X.71*
3. *Shevon Naomi Howard. Health Literacy Program Proposal for Health Care Workers. Walden University ScholarWorks. 2016.X.16*
4. *Hai Bin HE, Yang Lv* 和海滨, 吕洋, 高莉敏. 国内外健康素养研究现状综述. 医学信息学杂志*2017;38(1):7-10*
5. *БНХАУ ."Эрүүл Хятад 2030" стратеги төлөвлөгөө. 2016.* 中共中央、国务院. 中共中央国务院印发《“健康中国2030”规划纲要》[*EB/OL].[2018-09-10].http://www.gov.cn/zhengce/2016-10/25/content_5124174.htm.*
6. *Сувилахуйн тусламж үйлчилгээний гарын авлага. ДЭМБ. 2016.X.78-79*

Evaluation of health literacy among the inner mongolian citizens

Hong Yan[1], Solongo D[2], Lkhagvasuren Ts[2], Naranchimeg S[2]

[1]Inner Mongolia University for Nationalities
[2]MNUMS
Email: 03hongyan@163.com, Tel: 99562948

Introduction: In recent years, many countries are conducting the studies on the assessment of the “Health Literacy” concept; in its turn, these research works cover the quality of the health care and services and its changes too.
Purpose: The study aimed to evaluate the health literacy among the Inner Mongolian citizens.
Methods and materials: We employed analytical cross-sectional research method for the study. It covered totally 742 inner Mongolian citizens and they were asked by ‘Health literacy’ survey questionnaire published by WHO. The survey questions were prepared by the table that were developed by the American researchers Price, Dake, Murnan. The statistical analysis was performed by SPSS-23.
Results: The 9%, 38.5%, 22.1% and 8.2% of the participants were at age of 18-30, 31-40, 41-50, and above 61, respectively. The 54.2% of the respondents evaluated their health as “good”, 1.2% - as “very bad”. According to the evaluation of the citizens health,37.8% of the people were sick more than one, 33.4% of them smoked, and 67.8% were alcoholics. Regarding the health improvement decision, the 3.4% of respondents said that they had serious problems, while 49.3% of them answered that they had problems. And 58.8% of them answered that they can easily do the exercises, but the 1.3% of them had very serious problems to do the exercises.
Conclusion: We concluded that the survey participants evaluated their health as “average” or “lower than average” (37.5%), people who were admitted to the hospital multiple times were 37.8% - the 33.4% of them were smokers, and 49.3% have some health improvement decision making difficulties. Thus, we see the need for providing the training on health knowledge and skills among the certain number of the population.

Key word: Inner Mongolia, Health, Health knowledge, Evaluation